

Гадаадын зарим улсын шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, цахим технологийг хэрэглэж буй нөхцөл байдал

Содномцэрэнгийн ЗАЯАДЭЛГЭР*

-
- I. Оршил
 - II. Үндсэн хэсэг
 - 1. Бүгд Найрамдах Сингапур Улс
 - 2. Бүгд Найрамдах Солонгос Улс
 - 3. Америкийн Нэгдсэн Улс
 - 4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс
 - 5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
 - III. Дүгнэлт
-



* Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Шихихутуг их сургуулийн Ахисан түвшний сургуулийн докторант



Гадаадын зарим улсын шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, цахим технологийг хэрэглэж буй нөхцөл байдал

Содномцэрэнгийн ЗАЯАДЭЛГЭР *Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Шихихутуг их сургуулийн Ахисан түвшний сургуулийн докторант.*

Хураангуй: Энэхүү өгүүллээр хиймэл оюун ухаан болон цахим технологийг гадаадын зарим орнууд шүүхийн хэрэглээнд нэвтрүүлсэн сайн туршлагыг судалж, Монгол Улсад өрнөж эхлээд буй шүүхийн цахимжилтыг амжилттай хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудалд дүгнэлт өгсөн болно. Ингэхдээ Бүгд Найрамдах Сингапур Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын шүүхийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй технологи, нийгэм, олон нийтэд үзүүлэх үр нөлөө зэргийг харьцуулан судаллаа. Мөн шүүхийн хиймэл оюуны хэрэглээнд тавигдах зарим хязгаарлалт нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчмыг бэхжүүлэхэд ач холбогдолтой эсэх талаар судалсан болно.

Түлхүүр үг

Шүүхийн цахимжилт, хиймэл оюун ухаан, цахим технологи, цахим шүүх, цахим шинэчлэл.

I. ОРШИЛ

Дэлхий даяар цахим технологи, хиймэл оюун ухааны хэрэглээ эрс нэмэгдэж байгаатай холбоотойгоор эдгээр технологийг төрийн үйл ажиллагаанд ашиглан төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, хялбар болгох, нөгөө талаас төрийн албаны ачааллыг бууруулах, зардлыг хэмнэх чиглэлд ашиглах хандлага ажиглагдаж байна.

Монгол Улсын хувьд Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн 33 дугаар тогтоолоор "Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого"-ыг баталсан бөгөөд тус бодлогын зорилт 3.1-д "Шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, шуурхай, чирэгдэлгүй болгоно" хэмээн шүүх эрх мэдлийн хөгжлийн зорилтыг тодорхойлсон. Энэхүү зорилтын хүрээнд Шүүхийн Ерөнхий Зөвлөл (цаашид "ШЕЗ" гэх)-өөс 2022 онд "Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого"-ыг баталж, 2024 оноос "Цахим шүүх 2.0" цөм системийн хөгжүүлэлтийг хийж эхэлжээ.



Монгол Улсад шүүхийн үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлэх ажил хэрэгжиж эхэлсэн тул энэхүү ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс цахим технологийг шүүхийн үйл ажиллагаанд амжилттай нэвтрүүлж, хэрэгжүүлж буй гадаад орнуудын сайн туршлагыг судлах шаардлагатай байна. Иймд энэхүү өгүүллийн хүрээнд шүүхийн цахимжилтаар анхдагч улсууд болох Бүгд Найрамдах Сингапур Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын шүүхийн үйл ажиллагаанд цахим технологийг амжилттай нэвтрүүлсэн туршлагыг судлах болно.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

1. Бүгд Найрамдах Сингапур Улс

Бүгд Найрамдах Сингапур Улс (цаашид "Сингапур" гэх) нь цахим засаглал, төрийн үйлчилгээний цахимжилтаар дэлхийд тэргүүлэгч орны нэг бөгөөд шүүхийн тогтолцоог бүхэлд нь цахим хэлбэрт шилжүүлсэн анхдагч улс орнуудын тоонд багтдаг. Тус улс нь "Smart Nation" үндэсний бодлогын хүрээнд шүүхийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, eLitigation, CJTS (Community Justice and Tribunals System), iFAMS, ICMS зэрэг нэгдсэн системүүдийг нэвтрүүлсэн бөгөөд 2023-2025 оны хооронд хиймэл оюун ухаанд суурилсан шийдлүүдийг системтэйгээр хөгжүүлж Сингапурын Шүүхийн Захиргаа (англ. *Judiciary of Singapore*) болон "GovTech" агентлаг хамтран Generative Artificial Intelligence (GenAI)-г шүүхийн өдөр тутмын ажиллагаанд туршиж, үе шаттайгаар нэвтрүүлсэн байна.¹

2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Сингапурын шүүхээс Generative AI хэрэгслийг ашиглах шүүхийн хэрэглэгчдэд зориулсан гарын авлага (англ. *Guide on the Use of Generative Artificial Intelligence Tools by Court Users*)-ыг² нийтэлж, олон нийтэд танилцуулсан байна.

Хиймэл оюун ухааныг хэргийн материал хураангуйлах, баримт бичигт дүн шинжилгээ хийх, хууль зүйн судалгаа, хайлт хийх, гадаад хэл дээрх баримт бичгийг орчуулах, шүүхийн захиргааны ажлыг автоматжуулах, иргэдэд хууль зүйн мэдээлэл, үйлчилгээ хүргэх зорилгоор хязгаарлагдмал хүрээнд ашиглаж байна.³ Энэ нь хиймэл оюун ухааныг шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах, процессыг илүү үр ашигтай болгох хэрэгсэл болгон ашиглаж буй бодит жишээ юм.

Сингапурын шүүхийн хиймэл оюуны талаарх судалгаанд Generative AI-ийн онцлог шинжийг тодорхой тайлбарласан байдаг. Тухайлбал, том хэлний загварууд (англ. *Large Language Models*) нь магадлалд суурилсан систем бөгөөд бодит бус, ташаа мэдээлэл (англ. *hallucination*) үүсгэх эрсдэлтэй болохыг онцолсон байна.⁴

¹ Issuing a national AI strategy to harness AI's potential, <https://www.techandjustice.bsg.ox.ac.uk/research/singapore> (last visited Feb.3, 2026)

² The Guide on the use of Generative Artificial Intelligence Tools by Court Users (2024), <https://www.judiciary.gov.sg/news-and-resources/court-guides> (last visited Feb.4, 2026)

³ Supra note 1.

⁴ Supra note 2.



Иймд дээрх эрсдлээс сэргийлэх зорилгоор Хиймэл оюун ухааны удирдлагын хүрээ (англ. *A Model AI Governance Framework*)-г тодорхойлсон гарын авлагыг баталсан ба үүнд хууль зүйн салбарт хэргийн бодит байдлыг тогтоох нь чухал ач холбогдолтой тул хиймэл оюун ухааныг заавал хүний хяналт дор ашиглах ёстой гэж заажээ.

Сингапурын шүүхэд дараах хиймэл оюуны платформуудыг ашиглаж байна. Үүнд:

Хүснэгт 1. Сингапурын шүүхийн хиймэл оюуны үндсэн платформууд

<p>AI Bots – Шүүхийн дотоод хиймэл оюуны платформ</p>	<p>AI Bots нь Сингапурын GovTech агентлагийн хөгжүүлсэн “Whole of Government” буюу төрийн нэгдсэн цахим экосистемийн бүтээгдэхүүн бөгөөд төрийн байгууллагууд өөрийн дотоод баримтад суурилсан, тусгай зориулалтын Generative AI chatbot бүтээх боломжит платформ юм. Энэхүү системийг Сингапурын шүүхийн байгууллагууд дотоод журам, заавар, бодлогын баримт бичгүүдийг тайлбарлах, хүний нөөц, худалдан авалтын мэдээллийг боловсруулах, байгууллагын мэдлэгийн сангаас мэдээлэл хайх, захиргааны асуултад шуурхай хариу өгөх зэрэг чиглэлд ашиглагдаж байна. AI Bots платформын онцлог нь Retrieval-Augmented Generation (RAG) технологид суурилдаг бөгөөд энэ нь хиймэл оюуны хариуг зөвхөн шүүхийн баталгаажсан, ангилал бүхий баримтаас татан гаргах боломжийг бүрдүүлдэг. Ингэснээр олон нийтийн нээлттэй эх сурвалжид тулгуурласан, баталгаагүй мэдээлэл ашиглагдах эрсдэлийг бууруулж, шүүхийн дотоод орчинд аюулгүй, хяналттай хиймэл оюуны хэрэглээг бий болгож байна.⁵</p>
<p>Pair chat – Шүүхийн ажилтнуудад зориулсан AI туслах</p>	<p>Pair Chat нь GovTech агентлагийн хөгжүүлсэн reasoning engine буюу логик дүгнэлт хийх чадвартай хиймэл оюуны систем бөгөөд шүүхийн захиргааны ажилтнууд, шүүгчид, хуульчдын өдөр тутмын ажилд интерактив байдлаар туслах зорилготой. Энэхүү систем нь харилцан ярианы хэлбэрээр ажиллаж, баримт бичиг боловсруулах, эрх зүйн асуудалд анализ хийх, шийдвэрийн төсөл боловсруулах зэрэг олон төрлийн оюуны ажлыг дэмждэг. Pair Chat нь уламжлалт утгаар мэдлэгийн сангаас бэлэн хариу өгдөг chatbot биш, харин хэрэглэгчийн асуултад логик reasoning хийж, бодолцож, олон хувилбар дэвшүүлдэг ухаалаг туслах хэлбэртэйгээр ажилладаг нь түүний гол онцлог юм.⁶ Энэ нь шүүхийн ажилтнуудад баримт бичиг боловсруулах чанарыг сайжруулах, алдаа багасгах, бүтээмжийг нэмэгдүүлэх бодит дэмжлэг болж байна.</p>

⁵ AI Bots of Government Technology Agency of Singapore, <https://www.tech.gov.sg/products-and-services/for-government-agencies/productivity-and-marketing/aibots/> (last visited Feb.3, 2026)

⁶ Pair of Government Technology Agency of Singapore, <https://www.tech.gov.sg/products-and-services/for-government-agencies/productivity-and-marketing/pair/> (last visited Feb.3, 2026)



<p>Pair Search - Шүүхийн шийдвэрийн ухаалаг хайлт</p>	<p>Pair Search нь Open Government Products-тай хамтран хөгжүүлсэн ухаалаг хайлтын систем бөгөөд шүүхийн шийдвэр, хууль тогтоомж, парламентын хэлэлцүүлгийн тэмдэглэл, төрийн албан ёсны бүртгэл зэрэг эх сурвалжуудаас хиймэл оюунд суурилсан хайлт хийх боломжийг олгодог.⁷ Энэхүү систем нь дээд шүүхийн шийдвэрүүд, Hansard буюу парламентын албан ёсны тэмдэглэл, хүчин төгөлдөр хууль тогтоомж, бусад албан ёсны баримтуудыг нэгтгэсэн орчинд ажилладаг.</p> <p>Ингэснээр шүүгч, хуульчид, судлаачид олон баримтаас холбогдох эх сурвалжийг богино хугацаанд олох, ижил төстэй шийдвэрүүдийг харьцуулах, эрх зүйн үндэслэлийг бүрэн дүүрэн судлах, боломж бүрдэж, шүүхийн шийдвэрийн чанар, нэгдмэл байдлыг хангахад чухал дэмжлэг үзүүлж байна.⁸</p>
--	--

Дээрхээс үзэхэд, Сингапурын шүүх нь шүүхийн ажилчид болон шүүхээр үйлчлүүлэгчдийн хэрэглээнд нийцүүлэн хиймэл оюун ухааны цогц системийг хэрэглээнд нэвтрүүлжээ. Эдгээр систем нь мэдээлэл, нотлох баримт боловсруулах, хайлт хийх, хууль зүйн дүн шинжилгээ хийх, шүүхийн шийдвэрийн төсөл боловсруулах чадвартай байна.

Хэдий шүүхийн хиймэл оюун ухаан нь эрх зүйн анализ, дүн шинжилгээ хийх чадвартай хэдий ч үүнийг шүүгч шууд шийдвэр гаргагч байдлаар, эсхүл шийдвэрийг урьдчилан таамаглах, эрх зүйн хариуцлага хүлээлгэх ажиллагааг автоматжуулах зорилгоор ашиглахыг хатуу хориглодог. Учир нь Сингапурын шүүхийн хиймэл оюуныг нэвтрүүлэх үндсэн философи, үзэл баримтлал нь хиймэл оюуныг шүүгчийг орлох хэрэгсэл бус, шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих, ачааллыг бууруулах, мэдээлэл боловсруулах хугацааг хэмнэх зорилготой юм. Энэ үзэл баримтлал нь "хиймэл оюун ухаан бол шийдвэр гаргагч биш, харин шүүгчийн туслах, дэмжих хэрэгсэл байна" гэсэн зарчмаар илэрхийлэгддэг.⁹

Үүнээс гадна, Сингапурын шүүхийн тусгай хиймэл оюун ухааны систем болон "Harvey AI" системийг шүүхийн үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хүснэгт 2. "Harvey AI" буюу Сингапурын шүүхийн тусгай "Generative AI" ¹⁰

<p>Harvey AI – Phase 1 (Орчуулгын систем)</p>	<p>Harvey AI-ийн эхний үе шат нь гадаад хэл дээрх баримт бичгийг англи хэл рүү автоматаар хөрвүүлэх орчуулгын модуль байв. Энэхүү системийг Сингапурын Community Justice and Tribunals System (CJTS)-д бүрэн уялдуулан нэвтрүүлснээр гадаадын иргэн, байгууллагатай холбоотой маргаан, олон улсын шинжтэй хэргүүдийг шийдвэрлэх явцад хэлний саад тотгорыг бууруулж, шүүхийн ажиллагааг илүү хүртээмжтэй болгож чадсан.</p>
--	---

⁷ Sundaresh Menon, *Judicial Leadership: Navigating Artificial Intelligence with Human Wisdom*, Keynote Lecture at the Judicial Perspectives 2025, Singapore. (Nov.25, 2025).

⁸ *Ibid.*

⁹ AI in the judiciary: A Singapore Courts perspective, <https://insight.thomsonreuters.com/sea/legal/posts/ai-in-the-judiciary-a-singapore-courts-perspective> (last visited Feb.3, 2026)

¹⁰ "Media Release: Accessible Justice in action: Small Claims Tribunals mark 40 years with public open house", SG Courts, December 10, 2025, <https://www.judiciary.gov.sg/news-and-resources/news/news-details/media-release-accessible-justice-in-action-small-claims-tribunals-mark-40-years-with-public-open-house>



<p>Harvey AI – Phase 2A (Дотоод кейс анализ, хураангуйлалт)</p>	<p>Энэхүү систем нь хэргийн материалыг уншиж, хэргийн товч дүгнэлт гаргах, нэхэмжлэгч болон хариуцагч талуудын байр суурийг ялган харуулах, баримтын логик дарааллыг нэгтгэн дүгнэдэг.¹¹</p> <p>Шүүгч шүүхийн системд "Request AI Summary" товчийг дарснаар тухайн хэргийн хиймэл оюунд суурилсан дүн шинжилгээ, хураангуй дүгнэлт автоматаар гарч ирдэг бөгөөд энэ нь хэргийн материалтай танилцах хугацааг үлэмж богиносгож, шүүх хуралдаанд бэлтгэх ажлыг хөнгөвчилж байна.</p>
<p>Harvey AI – Phase 2B (Иргэдэд зориулсан AI)</p>	<p>2025 оны 12 дугаар сард Harvey AI-ийн олон нийтэд зориулсан хувилбарыг нэвтрүүлснээр иргэд өөрийн хэргийн явц, агуулгыг илүү ойлгомжтой байдлаар хянах шүүхийн процедурын талаар тайлбар авах, эрх зүйн мэдээлэлд илүү хүртээмжтэй хандах боломж бүрдсэн. Энэхүү үе шат нь Access to Justice буюу шударга шүүхэд хандах хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд хууль зүйн мэргэжлийн тусламж, авах боломж хязгаарлагдмал иргэдэд бодит дэмжлэг болж байна.</p>

Сингапурын шүүхийн "Harvey AI" тусгай систем нь мөн шүүхийн захиргааны ажилчид болон шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн хэрэглээнд чиглэсэн бөгөөд гадаад хэлнээс орчуулга хийх, кейсд дүн шинжилгээ хийх, хэргийн агуулгыг хураангуйлах болон шүүхээр үйлчлүүлж буй иргэд өөрийн оролцож буй хэргийн явц, агуулгыг илүү хялбараар хянах боломжийг олгожээ.

Засгийн газраас мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор Мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх (англ. *Data Loss Prevention*) бүтээгдэхүүнийг GovTech төслийн хүрээнд бүтээжээ. Энэхүү бүтээгдэхүүн нь мэдээллийн эрсдлийн түвшнийг ангилах, хяналт тавих зорилготой бөгөөд мэдээлэл алдагдах эрсдлээс сэргийлэх үүднээс хэрэглэгчийн үйлдлийг мэдэгдэх, зогсоох зэрэг үйлдлийг хийдэг байна.¹²

Харин шүүхийн бичиг баримт, хэргийн материалууд нь энэхүү мэдээлэл хамгаалах тогтолцооны хүрээнд хамгаалагддаг тул шүүхийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангахын зэрэгцээ хиймэл оюун ухааныг бодит, хяналттай орчинд ашиглах боломжийг бүрдүүлжээ.

Дээрхээс дүгнэхэд, Сингапурын шүүхийн хиймэл оюун ухаан, цахим технологийг нэвтрүүлж буй туршлага нь шүүхийн шинэчлэлийг бодлого, эрх зүйн зохицуулалт, аюулгүй байдлын тогтолцоотой уялдуулан хэрэгжүүлж буй цогц загвар юм. Шүүхийн тогтолцоог бүрэн цахимжуулсны дараагийн шатанд Generative AI-г үе шаттайгаар нэвтрүүлж, шүүхийн үйл ажиллагааны үр ашиг, чанарыг сайжруулахад бодитоор нөлөөлж байна.

Сингапурын шүүх хиймэл оюун ухааныг шүүгчийн оронд шийдвэр гаргагч байдлаар ашиглах бус, харин баримт бичиг хураангуйлах, хууль зүйн судалгаа хийх, орчуулга, ухаалаг хайлт зэрэг шүүгчийн ажлыг дэмжих туслах хэрэгсэл байдлаар ашиглаж байна.

¹¹ "Singapore Courts rolls out new AI tool to help support, summarise Small Claims Tribunals cases", The Straitstimes, September 10, 2025, <https://www.straitstimes.com/singapore/singapore-courts-rolls-out-new-ai-tool-to-help-support-summarise-small-claims-tribunals-cases?ref=search-results>

¹² Data Loss Prevention, <https://www.tech.gov.sg/products-and-services/for-government-agencies/ict-and-infrastructure/data-loss-prevention/> (last visited Feb.4, 2026)



"AlBots", "Pair Chat", "Pair Search", "Harvey AI" зэрэг платформууд нь хүний хяналт дор ажилладаг тул худал мэдээлэл үүсгэх эрсдлийг бууруулж, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой байна. Мөн хиймэл оюун ухааны системүүд нь мэдээллийг ангилах бодлогын хүрээнд тусгаарлагдсан дотоод орчинд ажилладаг тул шүүхийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангаж буй сайн жишээ юм. Иймд Сингапурын шүүхийн туршлага нь шүүхийн салбарт хиймэл оюуныг аюулгүй, үр ашигтай нэвтрүүлэх жишиг загвар болж, Монгол Улсад хэрэгжүүлэхэд стратегийн чухал суурь туршлага болно.

2. Бүгд Найрамдах Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид "Солонгос" гэх) нь төрийн цахим засаглал, цахим дэд бүтцийн хөгжлөөр дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг бөгөөд энэхүү бодлогоо шүүхийн салбарт системтэйгээр амжилттай хэрэгжүүлсэн улс юм. Солонгосын шүүхийн байгууллага 2000-аад оноос эхлэн шүүхийн цахим мэдээллийн системийг үе шаттайгаар хөгжүүлж, өнөөдөр бүх шатны шүүхийг хамарсан цахим системийг бүрдүүлсэн байна.¹³

Солонгосын шүүх нь "Smart Court" буюу ухаалаг шүүхийн үзэл баримтлалд тулгуурлан "Big Data", хиймэл оюун ухаан, чатбот, онлайн шүүх хурал, статистик мэдээллийн дүн шинжилгээ, шүүхийн нэгдсэн мэдээллийн сан зэрэг олон бүрэлдэхүүн хэсэг бүхий цахим шүүхийн загварыг хөгжүүлсэн байна. Уг шинэчлэлийн зорилго нь шүүхийн үйл ажиллагааг илүү хурдан, ил тод, хүртээмжтэй, үр ашигтай болгох, шүүхэд хандах иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэжээ.¹⁴

Солонгосын шүүхийн цахим хөгжил нь үе шаттайгаар хэрэгжсэн бөгөөд эхний үед шүүхийн мэдээллийн сан, цахим хэргийн хөдөлгөөн зэрэг цахим үйлчилгээ нэвтэрч, улмаар нэгдсэн дата төв, кибер аюулгүй байдлын дэд бүтэц бүрдсэн байна. Ингэснээр шүүх нь бүрэн цахим орчин, өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоотой болж чадсан байна.

Мөн хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхдээ шүүх эрх мэдлийн хараат бус байдал, шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах бүрэн эрхийг хадгалах суурь зарчмыг нэн тэргүүнд тавьдаг. Солонгосын шүүхийн цахим бодлогын үзэл баримтлал нь хиймэл оюун ухааныг шийдвэр гаргагч бус, харин шүүхийн үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл боловсруулах чадварыг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг бууруулахад туслах хэрэгсэл байдлаар ашиглахад чиглэж байна. Учир нь хиймэл оюун ухаан шийдвэр гаргах нь иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох шүүгчийн хараат бус байдал, мэргэжлийн шүүлтийг орлох эрсдэлтэй гэж үздэг.¹⁵

¹³ Digitalization Progress, <https://eng.scourt.go.kr/eng/judiciary/eCourt/history.jsp> (last visited Fed.4, 2026)

¹⁴ The World Bank, *Digitalization of South Korea's Justice system 2 Enhancing Access and Efficiency*, (2003), 57.

¹⁵ "Announcement of guidelines on use of artificial intelligence in judiciary", Lexology, March 19, 2025, <https://www.lexology.com/library/detail.aspx?g=3de965db-8c9c-4938-af8c-5e4bc09c02dc>



Харин хиймэл оюуныг шүүхийн захиргааны үйл ажиллагаа, иргэдэд чиглэсэн үйлчилгээ, мэдээллийн дүн шинжилгээ, шүүхийн статистик боловсруулах, хэргийн хөдөлгөөний процессыг хөнгөвчлөх чиглэлд ашиглаж байна.¹⁶ Энэ нь хиймэл оюуныг шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах, шүүхийн үйл ажиллагааг илүү үр ашигтай болгох хэрэгсэл болгон ашиглаж буй бодит жишээ юм.

Солонгосын шүүхүүд нь дараах хиймэл оюуны болон цахим платформуудыг хэрэглээндээ нэвтрүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 3. Солонгосын шүүхийн хиймэл оюуны болон цахим платформууд

<p>"Big Data" болон шүүхийн статистик мэдээллийн систем</p>	<p>БНСУ-ын шүүх нь үндэсний хэмжээнд шүүхийн бүх шатны байгууллагын мэдээллийг нэгтгэсэн "Big Data" платформыг байгуулсан бөгөөд энэхүү платформ нь шүүх дэх хэрэг, шүүхийн шийдвэр, шүүх хуралдаан болон процессын мэдээллийг төвлөрүүлэн хадгалж, статистик дүн шинжилгээ хийдэг. Энэхүү систем нь шүүхийн ачаалал, хэрэг шийдвэрлэх хугацаа, шүүхийн бүтээмж, бүс нутгийн ялгаатай байдал зэрэг үзүүлэлтүүдийг бодитоор хэмжиж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлдэг.¹⁷</p> <p>Үүний үр дүнд шүүх бодит тоон мэдээлэлд үндэслэн шүүхийн нөөц хуваарилалт, шийдвэрийг гаргах боломжтой болсон байна.</p>
<p>Chatbot болон иргэдэд зориулсан ухаалаг үйлчилгээ</p>	<p>Солонгосын шүүх нь иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүрээнд чатбот болон ухаалаг зөвлөх системийг нэвтрүүлсэн байна.¹⁸ Энэхүү чатбот нь иргэдэд шүүхэд хандах журам, хэрэг үүсгэх дараалал, төлбөр хураамж, шүүх хуралдааны тов, баримт бичгийн загвар зэрэг мэдээллийг автоматаар хүргэх зориулалттай бөгөөд шүүхэд бие даан оролцож буй иргэдэд бодит дэмжлэг болж байна.</p> <p>Ингэснээр хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах боломж хязгаарлагдмал иргэдэд шүүхэд хандах үйл явц илүү ойлгомжтой, хүртээмжтэй болж, шүүхийн үйлчилгээний чанар сайжирч байна.</p>
<p>Шүүхийн шийдвэрийн нэгдсэн мэдээллийн сан</p>	<p>Солонгосын шүүхийн байгууллага шүүхийн шийдвэрийг олон нийтэд цахимаар нээлттэй хүргэх нэгдсэн мэдээллийн санг үүсгэсэн¹⁹ бөгөөд энэхүү системээр дамжуулан иргэд, хуульчид, судлаачид шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь унших, ижил төстэй шүүхийн шийдвэр хайх зэргээр шүүхийн практикийг судлах боломжтой болж, шүүхийн ил тод байдал нэмэгдсэн байна.</p>

¹⁶ Ibid.

¹⁷ "Supreme Court Takes First Step Toward Building "Judicial Big Data"...Analyzing Rulings and Trial Records with AI", The Asia Business Daily, April 22, 2025, <https://www.asiae.co.kr/en/article/2025042115310208603>

¹⁸ "Chatbots, Verdict Prediction, Compensation Claims... Foreign Courts Expanding AI Usage", The Asia Business Daily, January 15, 2025, <https://www.asiae.co.kr/en/article/2025011513515887158>

¹⁹ Public Services, <https://eng.scourt.go.kr/eng/judiciary/eCourt/public.jsp> (last visited Feb.4, 2026)



<p>Онлайн шүүх хурал ба хэргийн хөдөлгөөний цахим систем</p>	<p>БНСУ нь дэлхийд хамгийн эрт онлайн шүүх хурлын системийг нэвтрүүлсэн орнуудын нэг бөгөөд ялангуяа цар тахлын үед шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхэд энэхүү систем чухал үүрэг гүйцэтгэсэн.²⁰</p> <p>Онлайн шүүх хурлын систем нь шүүх хуралдааны хугацааг богиносгох оролцогчдын зардлыг бууруулах, алслагдсан бүс нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг эерэг үр нөлөө үзүүлжээ. Мөн нотлох баримтыг цахимаар бүрдүүлэх, хэргийн материалыг зайнаас хянан үзэх боломж бүрдсэн нь шүүхийн процессын үр ашгийг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн байна.²¹</p> <p>Тодруулбал, цахимаар нэхэмжлэл гаргах системийг 2010 оноос үе шаттайгаар шүүхийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж эхэлсэн байна.²²</p>
---	---

Дээрхээс үзэхэд, тус улс нь шүүхийн шийдвэр, статистик мэдээлэл, цахим шүүх хурал болон иргэдэд зориулагдсан ухаалаг "Chatbot" зэрэг үйлчилгээнд суурилсан нэгдсэн бүтцийг бүрдүүлсэн байна. Солонгосын шүүх нь үндэсний хэмжээний шүүхийн дата төвийг байгуулж, бүх шатны шүүхийн мэдээллийн системийг төвлөрүүлсэн бүтцэд (англ. Architecture) шилжүүлсэн байна. Энэхүү дата төв нь гэнэтийн нөхцөлд мэдээллийг сэргээх, тасралтгүй ажиллагааг хангах, кибер халдлагаас хамгаалах зориулалт бүхий өндөр түвшний хамгаалалтын системтэйгээр ажилладаг. Ингэснээр Солонгосын шүүхийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, тогтвортой ажиллагаа үндэсний стратегийн дэд бүтцийн түвшинд хамгаалагдаж байна.²³

Дээрхээс дүгнэхэд, БНСУ-ын шүүхийн хиймэл оюун болон цахим технологийн бодлого нь шүүхийн шийдвэрийг зөвхөн шүүгч гаргах бөгөөд, харин хиймэл оюун ухааныг шүүхийн захиргааны болон мэдээлэл боловсруулах түвшинд ашиглах загварт тулгуурлаж байна. Энэ нь цахим шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ шүүхийн хараат бус байдал, шударга ёсны зарчмыг алдагдуулахгүй байхад чухал ач холбогдолтой юм.

Солонгосын шүүхийн туршлага нь "Big Data"-д суурилсан удирдлага, иргэдэд чиглэсэн ухаалаг үйлчилгээ, онлайн шүүх хурал, нэгдсэн мэдээллийн сан, өндөр түвшний кибер аюулгүй байдал бүхий дата төвийн бүтэц зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдуулсан орчин үеийн шүүхийн загварыг бүрдүүлсэн бөгөөд энэ нь Азийн бүс нутагт шүүхийн цахим шинэчлэлийн тэргүүлэх жишээ болж байна.

3. Америкийн Нэгдсэн Улс

Америкийн Нэгдсэн Улс (цаашид "АНУ" гэх) нь төрийн цахим шилжилт, мэдээллийн технологийн хөгжлөөр дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг бөгөөд

²⁰ The World Bank, Digitalization of South Korea's Justice system 2 Enhancing Access and Efficiency, (2003), 20.

²¹ "[Korean Law Insights] The Video Trial System of Korean Courts", K-Law Consulting, March 15, 2025, <https://www.k-lawconsulting.com/post/%ED%95%9C%EA%B5%AD-%EB%B2%95-%EC%9D%B4%EC%95%BC%EA%B8%B0-%ED%95%9C%EA%B5%AD-%EB%B2%95%EC%9B%90%EC%9D%98-%EC%98%81%EC%83%81%EC%9E%AC%ED%8C%90-%EC%A0%9C%EB%8F%84>

²² Ibid.

²³ The World Bank, supra note 21. 53.



энэхүү бодлогыг шүүхийн үйл ажиллагаанд амжилттай хэрэгжүүлж ирсэн улс юм. АНУ-ын шүүхийн тогтолцоо нь холбооны болон мужийн шүүхийн бие даасан бүтэцтэй хэдий ч мэдээллийн технологийн нэгдсэн бодлого, стандартын хүрээнд шүүхийн цахим шинэчлэлийг хэрэгжүүлж байна.

2000-аад оноос эхлэн АНУ-ын шүүх цахим хэргийн хөдөлгөөн, шүүхийн архивын цахим сан, онлайн үйлчилгээ, нэгдсэн дата төв, кибер аюулгүй байдлын архитектурт суурилсан цахим экосистемийг үе шаттайгаар хөгжүүлжээ.²⁴ Өнөөдөр холбооны шүүхийн бүх шатанд цахимаар хэрэг үүсгэх, цахим нотлох баримт бүрдүүлэх, цахим шүүх хурал явуулах, шүүхийн шийдвэрийг олон нийтэд цахимаар хүргэх нэгдсэн систем бүрэн хэрэгжиж байна.

Шүүхийн цахимжилт нь кибер аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлэх аюултай тул АНУ-ын шүүхийн цахим шинэчлэлийн зорилго нь шүүхийн захиргааны ажилчдыг чадавхжуулж, шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн шүүхэд хандах хүртээмжийг сайжруулах, шүүхийн ачааллыг бууруулах, шүүхийн процессын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэж байна.²⁵

Мөн хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхдээ Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх эрх, шүүгчийн хараат бус байдал, шүүхийн шийдвэр гаргах бүрэн эрхийг чандлан хамгаалах зарчмыг нэн тэргүүнд баримталдаг. АНУ-ын шүүхийн бодлогын үзэл баримтлал нь хиймэл оюуныг шийдвэр гаргагч бус, харин шүүхийн үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл боловсруулах, судалгаа, анализ хийхэд туслах хэрэгсэл байдлаар ашиглахад чиглэж байна. Учир нь хиймэл оюуныг шийдвэр гаргах, хариуцлага тооцоход ашиглах нь шударга шүүхийн зарчимд харшлах, ялгаварлан гадуурхах эрсдэл үүсгэх магадлалтай гэж үздэг.²⁶

Харин хиймэл оюуныг шүүхийн захиргааны үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дэмжих, мэдээллийн дүн шинжилгээ, шүүхийн статистик боловсруулах, хууль зүйн судалгаа, баримт бичиг боловсруулах, иргэдэд мэдээлэл хүргэх чиглэлд ашиглаж байна.

АНУ нь дараах хиймэл оюун ухааны болон цахим платформуудыг шүүхийн хэрэглээнд нэвтрүүлжээ. Үүнд:

²⁴ "64 Federal Courts Now Publish Opinions on FDsys" United States Courts, November 13, 2013, <https://www.uscourts.gov/data-news/judiciary-news/2013/11/13/64-federal-courts-now-publish-opinions-fdsys>

²⁵ Administrative Office of the United States Courts, *Long range Plan for information Technology in the Federal Judiciary: Fiscal Year 2026 Update*, Oct.2025, at 2.

²⁶ Principles & practices for AI use in courts (2025), <https://nationalcenterforstatecourts.app.box.com/v/AI-principles-and-practices>



АНУ-ын шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлттэй хүргэх, цахимаар нотлох баримт бүрдүүлэх, хадгалах, зайнаас цахимаар шүүх хуралд оролцох болон хиймэл оюун ухааны платформуудыг ашиглан эрх зүйн практикийг судлахад чиглэсэн цахим технологийг шүүхийн хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

Мөн холбооны шүүх нь үндэсний хэмжээний шүүхийн дата төвүүдийг байгуулж, бүх шатны шүүхийн мэдээллийн системийг төвлөрсөн бүтцэд суурилуулсан байна. Эдгээр дата төвүүд нь гамшгийн нөхцөлд мэдээлэл сэргээх, тасралтгүй ажиллагааг хангах, өндөр түвшний кибер хамгаалалтын системтэйгээр ажилладаг.³⁴

Дээрхээс дүгнэхэд, Америкийн Нэгдсэн Улсын шүүхийн хиймэл оюун болон цахим технологийн бодлого нь хиймэл оюун ухааны хэрэглээг шүүхийн шийдвэр гаргах бүрэн эрхэд нөлөөлөхгүй байхаар зохицуулж, зөвхөн судалгаа, анализ, захиргааны үйл ажиллагаа, мэдээлэл боловсруулах түвшинд үр ашигтай ашиглах загварт тулгуурлаж байна. Энэ нь шударга шүүхийн зарчимд нийцүүлэн цахим шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх боломжтойг харуулсан бодит жишээ юм.

АНУ-ын шүүхийн туршлага нь цахим хэргийн хөдөлгөөн, нэгдсэн баримтын сан, хиймэл оюунд суурилсан хууль зүйн судалгаа, онлайн шүүх хурал, өндөр түвшний кибер аюулгүй байдал зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдуулсан нэгдсэн бүтэц бүхий орчин үеийн шүүхийн загварыг бүрдүүлсэн бөгөөд энэ нь дэлхийн шүүхийн цахим засаглалын жишиг загвар болж байна.

4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид "Хятад" гэх) нь төрийн удирдлага, нийгмийн үйлчилгээ, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд цахим технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухааныг стратегийн түвшинд хэрэгжүүлж буй дэлхийн тэргүүлэх орнуудын нэг юм. Энэхүү бодлогыг шүүхийн салбарт "Smart Court" буюу ухаалаг шүүхийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд системтэйгээр хэрэгжүүлж байна.

Хятадын Ардын Дээд Шүүх нь 2016 оноос эхлэн "Smart Court" хөгжлийн үндэсний стратегийг хэрэгжүүлж, бүх шатны шүүхийг хамарсан нэгдсэн цахим цогц системийг байгуулжээ.³⁵ Энэхүү цогц систем нь цахим хэргийн хөдөлгөөн, онлайн шүүх хурал, шүүхийн шийдвэрийн нэгдсэн мэдээллийн сан, хиймэл оюунд суурилсан кейс анализ, шүүхийн статистик, шүүхийн захиргааны автоматжуулалт зэрэг олон бүрэлдэхүүн хэсгээс бүрддэг.

Хятадын шүүхийн цахим шинэчлэлийн зорилго нь шүүхийн ачааллыг бууруулах, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг богиносгох, шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн шүүхэд хандах хүртээмжийг өргөжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхдээ шүүхийн үйл ажиллагааг бүхэлд нь цахим орчинд шилжүүлэх, өгөгдөлд суурилсан удирдлагыг

³⁴ Information Systems and Cybersecurity – Annual Report 2024, <https://www.uscourts.gov/data-news/reports/annual-reports/directors-annual-report/annual-report-2024/information-systems-and-cybersecurity-annual-report-2024> (last visited Feb.4, 2026)

³⁵ "China expands smart court system", The Supreme People's Court of the People's Republic of China, November 19, 2017, https://english.court.gov.cn/2017-11/19/c_769177.htm (last visited Feb.4, 2026)



бий болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчлөх бодлогын хүрээнд ашиглаж байна. Мөн шүүхийн цахим шинэчлэлийн үзэл баримтлал нь хиймэл оюуныг шүүхийн шийдвэрийг бүрэн орлох хэрэгсэл бус, харин шүүхийн ажлыг хурдасгах, баримт боловсруулах, кейсийн анализ хийх, ижил төстэй хэрэг хайх, шийдвэрийн нэгдмэл байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх систем байдлаар ашиглахад чиглэж байна.³⁶

Хиймэл оюуныг ялангуяа бага үнийн дүнтэй маргаан, цахим худалдаа, хэрэглэгчийн маргаан, зээлийн маргаан зэрэг практикт их гардаг, стандартжуулах боломжтой хэргүүдэд ашиглан шүүхийн ачааллыг мэдэгдэхүйц бууруулж байна.³⁷

Шүүх нь дараах хиймэл оюуны болон цахим платформуудыг өргөнөөр ашиглаж байна. Үүнд:

Хүснэгт 5. Хятадын шүүхийн хиймэл оюуны болон цахим платформууд

<p>Хэргийн хөдөлгөөний цахим нэгдсэн систем</p>	<p>БНХАУ-ын бүх шатны шүүх нь нэгдсэн хэргийн хөдөлгөөний цахим системд холбогдсон бөгөөд хэрэг бүртгэл, баримт бүрдүүлэлт, нотлох баримтын цахим хадгалалт, процессын удирдлагыг нэг цонхоор гүйцэтгэх боломжтой болсон байна. Энэхүү систем нь улс даяарх шүүхийн бүх хэргийг нэгтгэсэн үндэсний хэмжээний мэдээллийн санг бүрдүүлж, бодлого төлөвлөлтөд ашиглагддаг.</p>
<p>Шүүхийн хиймэл оюунд суурилсан кейс анализ ба ухаалаг туслах</p>	<p>Хятадын шүүхэд "AI Judge Assistant" буюу шүүгчийн ухаалаг туслах системийг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь:³⁸</p> <ul style="list-style-type: none"> • хэргийн материалыг автоматаар унших; • нотлох баримт бүрдүүлэх; • ижил төстэй хэргүүдийг хайх; • хууль зүйн үндэслэлийг санал болгох; • шийдвэрийн логик алдааг илрүүлэх зэрэг чадвартай систем нь шүүгчийн шийдвэр гаргах үйл явцыг орлохгүй боловч шийдвэрийн төсөл боловсруулах, баримтыг шалгах, хууль зүйн үндэслэлийг баталгаажуулахад бодит дэмжлэг үзүүлж байна.
<p>Онлайн шүүх хурал ба интернэт шүүхүүд</p>	<p>Хятад Улс нь дэлхийд анх удаа "Internet Court" буюу цахим орчны маргааныг шийдвэрлэх тусгай шүүхүүдийг байгуулсан орон юм. Бээжин, Ханжоу, Гуанжоу хотод байгуулагдсан интернэт шүүхүүд нь цахим худалдаа, цахим гэрээ, оюуны өмч, онлайн залилан, дата хамгааллын маргааныг бүрэн цахим орчинд шийдвэрлэдэг.³⁹</p> <p>Онлайн шүүх хурал нь видео хурал, блокчейн баталгаажуулалт, хиймэл оюунд суурилсан цахим нотлох баримтын хүрээнд явагддаг.⁴⁰</p>

³⁶ Changqing Shi, Tania Sourdin, Bin Li, "The Smart Court – A New Pathway to Justice in China?", *International Journal for Court Administration* 12, no1, (May 2021), 2, <https://iacajournal.org/articles/10.36745/ijca.367>

³⁷ Ibid.

³⁸ China's "Smart Courts" Initiative: A Case Study in AI Integration, <https://lexir.co/2024/09/20/chinas-smart-courts-initiative-a-case-study-in-ai-integration/> (last visited Feb.4, 2026)

³⁹ "New regulation adjusts jurisdiction of internet courts", Beijing Internet Court, October 13, 2025, https://english.bjinternetcourt.gov.cn/2025-10/13/c_817.htm

⁴⁰ "China: Supreme Court Issues Rules on Internet Courts, Allowing for Blockchain Evidence", Library of Congress, September 21, 2018, <https://www.loc.gov/item/global-legal-monitor/2018-09-21/china-supreme-court-issues-rules-on-internet-courts-allowing-for-blockchain-evidence/>



Шүүхийн шийдвэрийн нэгдсэн мэдээллийн сан	Хятадын Ардын Дээд Шүүх нь "China Judgments Online" нэртэй үндэсний хэмжээний мэдээллийн санг байгуулж, бүх шатны шүүхийн шийдвэрийг олон нийтэд цахимаар нээлттэй хүргэдэг. Энэхүү систем нь дэлхийн хамгийн том шүүхийн шийдвэрийн сангуудын нэг бөгөөд жил бүр сая сая шийдвэр нэмэгддэг. ⁴¹
--	--

Хятадын шүүх нь цахимаар хэрэг бүртгэх, нотлох баримт бүрдүүлэх, хадгалах, төсөөтэй хэргийн хайлт хийх, хууль зүйн үндэслэлийг санал болгох систем болон шүүхийн шийдвэрийг олон нийт нээлттэй унших боломжтой мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд дэлхийд анх удаа цахим маргааныг шийдвэрлэх тусгай шүүх байгуулжээ.

Мөн кибер аюулгүй байдлыг хангах хүрээнд үндэсний хэмжээний шүүхийн дата төвүүдийг байгуулж, бүх шатны шүүхийн мэдээллийг төвлөрсөн санд суурилуулсан байна. Эдгээр дата төвүүд нь төрийн нууц, хувийн мэдээлэл, шүүхийн баримтыг хамгаалах өндөр түвшний кибер аюулгүй байдлын хамгаалалттай. Хятадын шүүхийн мэдээллийн системүүд нь Кибер аюулгүй байдлын хууль (англ. Cybersecurity Law), Өгөгдлийн аюулгүй байдлын хууль (англ. Data Security Law), Хувийн мэдээлэл хамгаалах хууль (англ. Personal Information Protection Law)-д нийцсэн байдлаар ажилладаг байна.⁴²

Дээрхээс дүгнэхэд, Хятадын шүүхийн хиймэл оюун болон цахим технологийн бодлого нь шүүхийн үйл ажиллагааг бүхэлд нь цахимжуулах, их өгөгдөлд суурилсан удирдлагыг бий болгох, хиймэл оюунд суурилсан ухаалаг шүүхийн цогц системийг бүрдүүлэх загварт тулгуурлаж байна. Энэ нь шүүхийн ачааллыг бууруулах, хэрэг шийдвэрлэх хугацааг богиносгох, шүүхийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн шүүхэд хандах хүртээмжийг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хятадын шүүхийн туршлага нь интернэт шүүх, хиймэл оюунд суурилсан кейс анализ, автоматжуулсан процесс, блокчейн нотлох баримт, үндэсний хэмжээний шүүхийн дата төвийн архитектур зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдуулсан дэлхийн хамгийн том ухаалаг шүүхийн загварыг бүрдүүлсэн бөгөөд энэ нь шүүхийн цахим засаглалын чухал жишиг болж байна.

5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид "Герман" гэх) нь Европын Холбооны гишүүн орны хувьд цахим засаглал, өгөгдөл хамгаалал, кибер аюулгүй байдлын нэгдсэн бодлогын хүрээнд шүүхийн шинэчлэлийг хэрэгжүүлж ирсэн улс юм. Германы шүүхийн байгууллага нь холбооны бүтэцтэй тул шүүхийн мэдээллийн технологийн бодлого, дэд бүтэц нь холбооны болон муж улсын түвшинд уялдуулан хэрэгждэг онцлогтой юм.

⁴¹ "Court Reform in China", The Supreme People's Court of the People's Republic of China, March 14, 2017, https://english.court.gov.cn/2017-03/14/c_761593_8.htm

⁴² "China Regulates Network Data Security", China Justice Observer, November 19, 2024, <https://www.chinajusticeobserver.com/a/china-regulates-network-data-security>



Германы шүүхийн цахим шинэчлэлийн гол зорилго нь шүүхийн хэргийн хөдөлгөөнийг бүрэн цахимжуулах, шүүхийн баримтыг цаасгүй орчинд удирдах, шүүхийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн шүүхэд хандах хүртээмжийг сайжруулахад чиглэж байна. Энэ хүрээнд "E-Justice" үндэсний бодлогын хүрээнд бүх шатны шүүхийг хамарсан цахим хэргийн хөдөлгөөний тогтолцоог бүрдүүлсэн бөгөөд тус улсын хууль тогтоогч 2026 оноос эхлэн бүх шүүхийг цахим хэргийн хөдөлгөөний тогтолцоонд бүрэн шилжүүлэх эрх зүйн зохицуулалтыг баталсан. Ингэснээр хэргийн материал, нотлох баримт, процессын бичиг баримтыг цахим хэлбэрээр цуглуулах, хадгалагдах нөхцөл бүрджээ.⁴³ Энэхүү реформ нь хиймэл оюуныг шүүхийн ажиллагаанд ашиглах суурь дэд бүтцийг бүрдүүлж буй стратегийн ач холбогдолтой алхам юм.

Германы шүүхийн байгууллага хиймэл оюун ухааныг нэвтрүүлэхдээ хүний эрх, шударга шүүхээр шүүлгэх эрх, шүүхийн хараат бус байдлыг хамгаалах суурь зарчмыг нэн тэргүүнд баримталдаг. Европын Холбооны Хиймэл оюуны тухай хууль (AI Act)-ийн хүрээнд шүүх дэх хиймэл оюуны системүүдийг "өндөр эрсдэлтэй" ангилалд хамруулсан⁴⁴ бөгөөд энэ нь Германы дотоод бодлогод ч шууд нөлөөлж байна.

Германд хиймэл оюуныг шүүхийн шийдвэрийг автоматаар гаргах, ял болон хариуцлага тогтоох ажиллагаанд оролцуулахыг Үндсэн хуулиар⁴⁵ зөвшөөрдөггүй. Харин хиймэл оюуныг шүүхийн үйл ажиллагааг дэмжих, баримт бичиг боловсруулах, кейсийн материал боловсруулах, ижил төстэй хэрэг хайх, статистик мэдээлэл боловсруулах, захиргааны процессыг автоматжуулах чиглэлд ашиглагдаж байна.⁴⁶ Өөрөөр хэлбэл, Германы шүүхийн үзэл баримтлал нь "Human-in-the-loop" буюу шүүгчийн хяналт дор ажиллах хиймэл оюуны загварт тулгуурлаж, эцсийн шийдвэрийг заавал хүн /шүүгч/ гаргах зарчмыг чанд баримталдаг.⁴⁷

Шүүхийн цахим хэрэглээг дэмжих, шүүхийн ачааллыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс дараах платформуудыг шүүхийн хэрэглээнд нэвтрүүлжээ. Үүнд:

⁴³ CMS Expert Guide to Digital Litigation in Germany, <https://cms.law/en/int/expert-guides/cms-expert-guide-to-digital-litigation/germany> (last visited Feb.4, 2026)

⁴⁴ Artificial intelligence act (2024), <https://eur-lex.europa.eu/eli/reg/2024/1689/oj/eng>

⁴⁵ Basic Law for the Federal Republic of Germany (1949), art. 101(1) "... No one may be removed from the jurisdiction of his lawful judge"

⁴⁶ Digitalisation of civil proceedings in Germany, <https://www.nortonrosefulbright.com/en-419/knowledge/publications/3bc3c34a/digitalisation-of-civil-proceedings-in-germany> (last visited Feb.4, 2026)

⁴⁷ "The Evolving Role of AI in German Dispute Resolution", Hengeler Mueller, January 30, 2025, <https://hengeler-news.com/en/articles/the-evolving-role-of-ai-in-german-dispute-resolution>



Хүснэгт 6. Германы шүүхийн хиймэл оюун ухааны болон цахим платформууд

<p>Хэргийн хөдөлгөөний цахим нэгдсэн систем (E-Justice)</p>	<p>Германд бүх шатны шүүхийг хамарсан хэргийн хөдөлгөөний цахим системийг нэвтрүүлж, хэрэг бүртгэл, баримт бүрдүүлэлт, нотлох баримтын хадгалалт, процессын удирдлагыг цахим орчинд гүйцэтгэх боломжийг бүрдүүлж байна. Энэхүү систем нь холбооны болон муж улсын шүүхүүдийн хооронд өгөгдөл солилцох нэгдсэн архитектурт суурилсан. Цахим хэргийн хөдөлгөөн нь шүүхийн ачааллыг бууруулах, процессын хугацааг богиносгох, баримт бичгийн алдаа, давхардлыг багасгах бодит үр нөлөө үзүүлж байна.⁴⁸</p>
<p>OLGA – Иргэний хэргийн ухаалаг ангилалтын систем</p>	<p>Германы Баден-Вюртемберг мужид "OLGA" нэртэй хиймэл оюунд суурилсан системийг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь иргэдийн гаргасан нэхэмжлэлийг агуулгаар нь автоматаар ангилан бүлэглэх, ижил төстэй хэргүүдийг нэгтгэх, шүүхийн бүрэлдэхүүнд урьдчилсан мэдээлэл өгөх зориулалттай.⁴⁹</p> <p>OLGA систем нь:</p> <ul style="list-style-type: none"> • иргэний нэхэмжлэлийг ангилах • процессын үйл явцыг тодорхойлох • стандартчилагдсан маргаануудыг ялгах чиглэлд ашиглагддаг бөгөөд шүүхийн ажилтнуудын ачааллыг мэдэгдэхүйц бууруулжээ.
<p>Frauke – шийдвэрийн төсөл боловсруулах туслах систем</p>	<p>Франкфурт хотын шүүхэд "Frauke" нэртэй хиймэл оюунд суурилсан туслах системийг туршиж нэвтрүүлсэн бөгөөд энэхүү систем нь зорчигч тээврийн маргаан, нислэг саатлын нөхөн төлбөртэй холбоотой хэргүүдийн баримтаас өгөгдлийг автоматаар түүвэрлэж, шийдвэрийн төсөл боловсруулахад шүүгчид тусалдаг. "Frauke" систем нь шүүхийн шийдвэрийг автоматаар гаргахгүй, харин стандартжих боломжтой хэргийн шийдвэрийн төсөл боловсруулах ажлыг хурдасгаж, шүүгчийн анхаарлыг илүү төвөгтэй асуудалд чиглүүлэх боломж олгодог.⁵⁰</p>
<p>Онлайн шүүх хурал ба цахим процесс</p>	<p>Германы шүүхийн байгууллага иргэний болон захиргааны хэргүүдэд видео хурлын системийг өргөн ашиглаж, талуудыг зайнаас оролцуулах боломжийг нэмэгдүүлсэн. Энэ нь шүүхийн хүртээмжийг сайжруулах, процессын зардлыг бууруулах, хуралдааны хугацааг оновчлох эерэг нөлөө үзүүлж байна.⁵¹</p> <p>Цахим процессын хүрээнд баримт бичгийг цахимаар бүрдүүлэх, цахим гарын үсэг ашиглах, цахим мэдэгдэл хүргэх тогтолцоо бүрдсэн нь шүүхийн ажиллагааг илүү хурдан, найдвартай болгожээ.</p>

Германы шүүх нь хэргийн хөдөлгөөний цахим системээр дамжуулан цахимаар нотлох баримт бүрдүүлж, хадгалж байгаа бөгөөд хиймэл оюунд суурилсан системийн тусламжтайгаар автоматаар нэхэмжлэлийг ангилах, маргааныг ялгах боломжтой болжээ. Мөн цахимаар шүүх хурал зохион байгуулах

⁴⁸ *Supra note 44.*

⁴⁹ "Judicial systems are turning to AI to help manage vast quantities of data and expedite case resolution", IBM, February 4, 2025, <https://www.ibm.com/case-studies/blog/judicial-systems-are-turning-to-ai-to-help-manage-its-vast-quantities-of-data-and-expedite-case-resolution>

⁵⁰ *Ibid.*

⁵¹ "German Civil Procedure Goes Digital – New regulation on virtual participation in oral hearings", Freshfields, July 26, 2024, <https://riskandcompliance.freshfields.com/post/102jep3/german-civil-procedure-goes-digital-new-regulation-on-virtual-participation-in>



боломжтой болсноор шүүхийн үйл ажиллагаа илүү хүртээмжтэй болсон бөгөөд хиймэл оюунд суурилсан системийн тусламжтайгаар зарим төрлийн хэргийн шийдвэрийн төслийг боловсруулах боломжтой болсон байна.

Шүүхийн мэдээллийн системүүд нь Европын Холбооны Ерөнхий өгөгдөл хамгаалах журам (англ. *General Data Protection Regulation*), Үндэсний мэдээлэл хамгаалах хууль, кибер аюулгүй байдлын стандартын дагуу хамгаалагддаг.⁵² Шүүхийн баримтууд нь өндөр түвшний нууцлал, хандалтын хяналт, аудитын тогтолцоонд хамрагддаг.

Дээрхээс дүгнэхэд, Германы шүүхийн хиймэл оюун болон цахим технологийн бодлого нь Европын хүний эрхийн тогтолцоо, шударга шүүхийн зарчим, өгөгдөл хамгаалалтын өндөр стандарттай уялдсан "хүний хяналттай хиймэл оюун" загварт тулгуурлаж байна. Шүүхийн шийдвэр гаргах бүрэн эрхийг хүний гарт хадгалж, харин хиймэл оюуныг баримт боловсруулах, кейс ангилах, стандартчилагдсан шийдвэрийн төсөл боловсруулах түвшинд ашиглаж буй нь Германы загварын онцлог юм.

Германы шүүхийн туршлага нь цахим хэргийн хөдөлгөөн, ухаалаг кейс ангилалт, шийдвэрийн төсөл боловсруулах туслах систем, онлайн шүүх хурал, өгөгдөл хамгаалалтын өндөр стандарт зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдуулсан Европын шүүхийн цахим засаглалын тэргүүлэх жишээ болж байна.

III. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны хүрээнд Сингапур, Солонгос, Хятад, АНУ, Герман улсуудын хиймэл оюун ухаан болон цахим технологийг шүүхийн үйл ажиллагаанд хэрхэн ашиглаж байгаа туршлагыг судаллаа. Тухайн улсууд нь шүүгч, шүүхийн захиргааны ажилчид болон шүүхээр үйлчлүүлж буй иргэд, олон нийтийн хэрэглээнд чиглэсэн технологийг нэвтрүүлсэн байна.

Тодруулбал, шүүгч болон шүүхийн захиргааны ажилчид хэргийн үйл баримтыг хураангуйлах, төсөөтэй шүүхийн шийдвэрийн хайлт хийх, логик зөрчлийг илрүүлэх, мөн хууль зүйн анализ хийхэд ашиглаж байна. Иргэд, олон нийтийн хувьд шүүхийн шийдвэрийг нээлттэй уншиж судлах, хэргийн явц, шүүх хуралдааны товтой цахимаар танилцах болон цахимаар буюу зайнаас шүүх хуралдаанд оролцох зэргээр ашиглаж байгаа бөгөөд энэ нь шүүхийн ачааллыг бууруулах, шүүхийн шийдвэрийн нэгдмэл байдлыг хангах, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой байна.

Харин хиймэл оюун ухаан болон цахим технологийг шүүгч болон шүүхийн захиргааны ажилчид хэрэглэхдээ зөвхөн шийдвэр гаргах процессыг хөнгөвчлөх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх байдлаар хэрэглэх ёстой байна. Өөрөөр хэлбэл, хиймэл оюун ухааныг шууд шийдвэр гаргагч байдлаар хэрэглэх нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдалд халддаг гэж үздэг тул зайлшгүй хүний хяналт дор ашиглахыг онцолжээ.

⁵² Data protection, <https://www.bverwg.de/en/datenschutz> (last visited Fed.4, 2026)



Монгол Улсын хувьд дээрх улсуудын сайн туршлагыг харгалзан шүүхийн системд хиймэл оюун ухаан, цахим технологийг үе шаттайгаар хэрэгжүүлснээр шүүхийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой юм. Гэхдээ хиймэл оюун ухаан, цахим технологийг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхдээ шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулалгүйгээр зохион байгуулах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Basic Law for the Federal Republic of Germany, 1949.
2. Sundaresh Menon, "Judicial Leadership: Navigating Artificial Intelligence with Human Wisdom", Keynote Lecture at the Judicial Perspectives 2025, 2025.
3. The World Bank, "Digitalization of South Korea's Justice system 2 Enhancing Access and Efficiency", 2003.
4. Administrative Office of the United States Courts, "Long range Plan for information Technology in the Federal Judiciary: Fiscal Year 2026 Update", 2025.
5. Changqing Shi, Tania Sourdin, Bin Li, "The Smart Court – A New Pathway to Justice in China?", International Journal for Court Administration 12, 2021.

2. Цахим эх сурвалж

1. Европын холбооны эрх зүйн мэдээллийн цахим сан: <https://eur-lex.europa.eu/>
2. Германы эрх зүйн мэдээллийн цахим сан: <https://www.gesetze-im-internet.de/>
3. Сингапурын шүүхийн цахим хуудас: <https://www.judiciary.gov.sg/>
4. Сингапурын Засгийн газрын технологийн агентлагийн цахим хуудас: <https://www.tech.gov.sg/>
5. Холбооны Захиргааны хэргийн шүүхийн цахим хуудас: <https://www.bverwg.de/en>
6. АНУ-ын шүүхийн цахим хуудас: <https://www.uscourts.gov/>
7. Улсын шүүхийн үндэсний төвийн цахим хуудас: <https://nationalcenterforstatecourts.account.box.com/>
8. Бээжингийн интернэт шүүхийн цахим хуудас: <https://english.bjinternetcourt.gov.cn/index.html>
9. "China Justice Observer" шүүхийн мэдээллийн цахим сан: <https://www.chinajusticeobserver.com/>
10. Солонгосын Дээд шүүхийн цахим хуудас: <https://eng.scourt.go.kr/eng/main/Main.work>
11. Оксфордын их сургуулийн "Technology and Justice" төвийн цахим хуудас: <https://www.techandjustice.bsg.ox.ac.uk/>.
12. "Thomson Reuters" технологийн компанийн цахим хуудас: <https://www.thomsonreuters.com.sg/en-sg.html>



13. "Straits Times" сонины цахим хуудас: <https://www.straitstimes.com/global>
14. Солонгосын Дээд шүүхийн цахим хуудас: <https://eng.scourt.go.kr/eng/main/Main.work>
15. "Lexology" эрх зүйн хайлтын систем: <https://www.lexology.com/>
16. Asia Business Daily цахим хуудас: <https://www.asiae.co.kr/en/>
17. "K-Law Consulting" хуулийн фирмийн цахим хуудас: <https://www.k-lawconsulting.com/>
18. "Lexis Nexis" компанийн цахим хуудас: <https://www.lexisnexis.com/en-us/gateway.page>
19. "Bloomberg Law" эрх зүйн мэдээллийн систем: <https://pro.bloomberglaw.com/>
20. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын дээд шүүхийн цахим хуудас: <https://english.court.gov.cn/>
21. Шүүхийн захиргааны олон улсын сэтгүүлийн цахим хуудас: <https://iacajournal.org/>
22. "Lexir" цахим мэдээллийн сан: <https://lexir.co/>
23. АНУ-ын конгрессийн номын сангийн цахим хуудас: <https://www.loc.gov/>
24. "CMS" хуулийн фирмийн цахим хуудас: <https://cms.law/en/int/>
25. Европын холбооны эрх зүйн мэдээллийн цахим сан: <https://eur-lex.europa.eu/>
26. "Norton Rose Fulbright" олон улсын хуулийн фирмийн цахим хуудас: <https://www.nortonrosefulbright.com/en-419>
27. "Hengeler Mueller" хуулийн фирмийн цахим хуудас: <https://www.hengeler.com/en>
28. "International Business Machine Corporation" компанийн цахим хуудас: <https://www.ibm.com/us-en>
29. "Freshfields" хуулийн фирмийн цахим хуудас: <https://www.freshfields.com/en/about-us>



Article

The conditions of use of artificial intelligence and digital technologies in judicial operations in certain foreign countries

ZAYADELGER Sodnomtseren*

Abstract: This article examines best practices from several foreign countries in integrating artificial intelligence and digital technologies into judicial systems, and provides conclusions on key considerations for successfully implementing the ongoing digitalization of the judiciary in Mongolia. In doing so, it conducts a comparative analysis of the technologies used in judicial operations in Singapore, South Korea, United States, China, and Germany, as well as their impacts on society and the public. It also examines whether certain restrictions on the use of artificial intelligence in the judiciary contribute to strengthening the principles of judicial autonomy and judicial independence.

Keywords: Judicial digitalization, artificial intelligence, digital court, digital reform

* Head of the Office of Supreme court of Mongolia.